

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

ЧИХЭН ДОТОР ЕРТӨНЦИЙГ “БАЙГУУЛАХ НЬ”

Д.Батжаргал*

* МУИС-ийн ШУС-ийн Утга зохиолын тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: радио сэтгүүл зүйн онцлог, үгээр зураглал бүтээх, нэвтрүүлгийг үг, дуу чимээ, хөгжим, дүрслэх яриа ашиглан бүтээх нь

Биднийг гучаад жилийн тэртээ радиод анх ажилд орж байхад “Радио бол чихэн дотор ертөнцийг байгуулах урлаг” хэмээн хүн болгон хэлдэг ярьдаг байлаа. Энэ бол нэгэн зуу гаруй жилийн түүхтэй радио сэтгүүл зүйн хувьд хамгийн оновчтой чухал афоризм. Социализмын их онолч В. И. Лениний “Радио бол цаасгүй сонин” гэсэн эшлэлтэй эн дүйцэхүйц тийм чухал үг.

Радиоогийн авьяаслаг сэтгүүлч Д.Пэлдэн “Радио сэтгүүлч микрофоноор зурж сурах хэрэгтэй” (Гандангийн дэнж, Радио, телевизийн төв байр, 1989 он) гэж нэгэн удаагийн хурал дээр хэлсэн нь бий. Микрофоноор зурахын хамгийн давуу тал нь хүний тархинд төсөөлөл, зураглал бий болгох явдал байдаг. Өөрөө ч тэрбээр үгээр сайн “зурдаг”, дүрслэлийг эрхэмд үздэг сэтгүүлч байлаа. “Тэрэгчин” тэмдэглэлдээ наяд оны сүүлчээр их дэлгүүрээс хөргөгч, буйдан, тавилга хэрэгсэл зэрэг том овортой бараа авсан хүмүүсийг

гэрт нь хүргэж өгдөг морин тэрэгчдийн тухай тун ч хөгжилтэй, басхүү наргиан хөөрөөтэй нэвтрүүлэг бэлтгэсэн байдаг. Үүнийг радиоогийн асуудал хөндсөн нэвтрүүлгийн тухай дараачийн өгүүлэлдээ нарийвчлан задлахаар түр хойш тавьж одоо аж байдлын сэдэвтэй “Лоолой...лоолой...” нэвтрүүлгийн тухай өгүүлье.

Энэ нэвтрүүлгийг сэтгүүлч Д.Батаа, найруулагч Д.Энхсайхан нар бэлтгэж нэвтрүүлэгчээр Доржсүрэн, Билгээ нар ажилласан байна. Найруулагч Доржсүрэнхорын Энхсайхан Буриадын Улаан-Үд хотын Соёлын дээд сургуулийг радиоогийн найруулагч мэргэжлээр төгссөн тул радио найруулгад үг, дуу чимээ, хөгжмөөр дүрслэхийг ихээхэн эрхэмлэдэг, сэтгүүлчдэд энэ шаардлагыг сайн тавьдаг уран бүтээлч байлаа. Нэвтрүүлэг нь Монголын радиоогийн нийслэлийн редакцийн “Амьдрах ухаан” нэвтрүүлгээр 1992 оны 12 дугаар сарын 4-ний өдөр нэвтэрсэн байна. Нэвтрүүлгийн эх бичвэр дээр тус редакцийн хариуцлагатай редактор Сэджавын Лхагвасүрэн мөн оны 11 дүгээр сарын 27-ний өдөр гарын үсгээ зурж “чанар” гэсэн үнэлгээ өгчээ.

“Лоолой... лоолой...” нэвтрүүлгээр суурин газарт гахай өсгөхийн ашиг тусыг өгүүлэхдээ зөвлөгөө байдлаар хялбар хийхийг бодсонгүй, радиогийн онцлогийг бодолцож хөтлөгчдийн харилцан яриа, гахайнд хандах хүмүүсийн хандлага, ад шоо үздэг сэтгэлгээ, тэгсэн атал амтат мах, хиам зэрэг бүтээгдэхүүнийг нь муу хэлдэг амаараа “амаа олохгүй шахам” үмхдэг талаар эсрэгцүүлэл ашиглан егөөтэй өгүүлжээ. Радиогийн онцлогийг түлхүү гаргасан тул олон зүйл нуршилгүй бичвэрийг бүрэн эхээр оруулж байна. Гэхдээ цаг цаас хэмнэх үүднээс эх сурвалжийн яриаг дурдах төдий утгачлав. (Эх бичвэрт нэвтрүүлэгчийг НЭВТ, сурвалжлагчийг СУРВ, соронзон бичлэг дэх эх сурвалжийн яриаг ХАЛЬС хэмээн товчилжээ.)

/эхлэл хөгжим/

НЭВТ: Амьдрах ухаан

/хөгжим/

НЭВТ: Лоолой... Лоолой...

/хөгжим/

НЭВТ: /эмэгтэй загнах аясаар/
Гахай шиг заваан, гахай шиг балиар...

НЭВТ: /жаахан хүүхэд шиг шингэн хоолойгоор/ Гахайн торой ээжийгээ хөхөхдөө яагаад нүдээ аньдаг юм бэ?

НЭВТ: /эрэгтэй хүүхэд дооглонгүй/
Ээж нь муухай болохоор ичдэг биз дээ. Хи...хи...

СУРВ: Гахайг бид ганц удаа ч сайн сайхнаар ярьж байсангүй. Бохир заваан газар гахай зурж тавина, болохгүй дүрсгүй хүүхдийг гахайтай л зүйрлэнэ. Гахай тэгтэл...

/Хальс: Суурин газарт

гахайн ашиг тус, үр шимийн тухай өгүүлнэ.../

НЭВТ: /эмэгтэй загнах аясаар/
Гахай шиг заваан, гахай шиг балиар...

/дуу/

Арынхаа

тариалангаар орлоо хө

Алтанхан ээмгээ гээлээ би

Харласан муу сайн

торойнууд

Хаашаа хаашаа тэнээ вэ?

Лоолой... лоолой...

Лоолойгоо дуудаад

аа алга уу даа

Лоолой... лоолой...

Дуудаад дуудаад...

алга уу...даа

СУРВ: Тээр... дуундаа хүртэл харласан мууг нь дуудаад л... Тэгтэл муулж байгаа энэ амаа олохгүй шахам амттай сайхан хиамыг нь үмхдэг атлаа, харин бид гахайг хайрлаж магтаж явсангүй, харааж доромжилсоор өдий хүрчээ.

НЭВТ: Гахай хариулсан хүн уураа бардаг гэдэг...

СУРВ: Уураа барагдтал ухаанаа урагдтал гахайг газар дор ортол муулдаг.

/Хальс: Байгууллага хамт олон бүхэн туслах аж ахуйг хөгжүүлж байх үед гахай их өсч байсан. Одоо Монголын гахай цөөрч байна.../

НЭВТ: Гахай газар сүйтгэдэг!

СУРВ: Эрдэнийн зүйлээр бөөлжөөд байдаг

Эрүү

цагаан

хулгана нэгэн жил

Эвэр сүүл нь
тэнцүүхэн байдаг

Эзэндээ ээлтэй
үхэр хоёр жил

...Хотгор газрыг
хорголоороо дүүргэдэг

Хотондоо ээлтэй
хонь найман жил... гэсэн атлаа
гахайг болохоор

Хөрст дэлхийг
сэндийлээд байдаг

Хөндлөн соёот
гахай 12 жил гэж хэлнэ

/хөгжим/

СУРВ: Гахай тэгтэл гарын
дор амьтан.

Хэвтэр бууц шилэхгүй

Хэний ч хашаанд өснө

Хивэг хаягдал голохгүй

Хээ шаагүй амьтаан

*/Хальс: Гахай маллах хүн
юу анхаарах, идэш тэжээл байр
орны тухай/*

/дуу/ Зүүнтээх
тариалангаар орлоо хөө

Зүүсэн ээмгээ гээлээ би

Зүггүй муу сайн торойнууд
нь хө

Зүг зүг рүүгээ тэнээд
явчихаа юу

Лоолой... лоолой ...

дуудаад

дуудаад алга уу даа.

СУРВ: Гахай заваан гэдэг ч, гал
тогоонд маань орж өт цацаагүй, цонхон
дээр суусан ялаа шиг цоохор халтар
толбо үлдээгээгүй, өрөө тасалгаа
дамжин тэнэж өвчний нян тараагаагүй.

НЭВТ: Дуу хуур гахайг тойрон
уянгалж, дуртгал найраг гахайг тойрон
эгшиглэсээр...

/Хөгжим/

НЭВТ: Олны нэг онож. Овоо доо,
хөөрхий. Гахайн торойг магтах найрагч
газар дээр бас байдаг байжээ.

*/Шум: гахай гүйлдэх чимээ
дэвсгэрлээд/*

НЭВТ: Томоос том хулгана гэмээр

Торойнууд

Тожигнолдон гүйлдэнэ

Товчны шилбэ шиг

Годгорхон сүүлээ

Гогцооруулан хурдална

Өнхөрсөн бөмбөг шиг

Өөгүй

Өсөхөөсөө тэд

Хээгүй

Цадаж таргалах нь гайхам

Цасан өнхрүүш гэлтэй

Томрон томрон торнино

Тожир тожир гүйлдэнэ

/Хөгжим/

*/Хальс: Гахайн ашиг шим гэр дүүрнэ
гэсэн яриа/*

НЭВТ: Амандаа орсон өөхийг
хэлээрээ түлхэнээ гэж байх. Манай
Монголын гахай яагаад цөөрөөд байна
аа. Зах зээл гахайг маань газар
дүүртэл өсгөх болтугай.

/Хөгжим/

НЭВТ: “Амьдрах ухаан”
нэвтрүүлгийн энэ ээлжээр “Лоолой...
лоолой” радио зохиомж сонсголоо.
Нэвтрүүлэгт мал аж ахуйн эрдэм
шинжилгээний хүрээлэнгийн ажилтан,
дэд эрдэмтэн Доржсүрэн оролцож,
гахайн ашиг шимийн талар ярилаа.
Мөн хүүхдийн зохиолч Нямжийн
Лхагваагийн “Торой” шүлгийг орууллаа.
Эрхлэн бэлтгэсэн Батаа, найруулагч
Энхсайхан, нэвтрүүлэгч Билгээ,
Доржсүрэн.

Энэ бол уралдаанд орох гэж
чармайж хичээж хийсэн бүтээл бус,

жирийн урсгал нэвтрүүлэг. Гэтэл Улаанбаатар радиогийн хорин жилийн дараах хоёр ч хөрөг нэвтрүүлэг сонсоход радиогийн онцлогийг ерөөс анхаараагүй хайнга хандсан тал харагдаж байна. Жишээ нь, алдарт дуучин Норовбанзадын тухай “Уяхан замбутивийн наран дор өнө мөнхөд оршигч” хөрөг нэвтрүүлэг 33 минут 40 секунд үргэлжилж байна. Энэ том нэвтрүүлэгт нэг ч эх сурвалжийн яриа (синхрон) байхгүй, дуулсан дуунаас нэг хоёрыг дэвсгэрлэн дан цагаан бичвэр оруулсан нь уйтгартай байна. Норовбанзад гуайн дуулж мөнхөлсөн гайхамшигт уртын дууны айзам хэмнэл, гүн цараатай хоолойн тухай урлаг судлаач төдийгүй захын хүн сайхан ярьж чадна. Хөгжмийн зохиолч Н.Жанцанноров солонгосын нэгэн хөгжим судлаачийн хэлсэн зүйлийн талаар ерээд оны эхээр тухай ийнхүү ярьсан юм. «Норовбанзад гуай дуулж байхад тэрхүү судлаач монгол хэл мэдэхгүй болохоор “Энэ ямар дуу вэ?” гэж асууж гэнэ. “Уяхан замбутивийн нар” гэж хэлэнгүүт шууд дуу алдаж “Тийм байх аа, ая нь аль хэдийн дэлхийгээс тасраад явчихлаа» гэж хэлсэн гэдэг. Ийм сайхан дуучин Норовбанзад гуайн тухай радио нэвтрүүлэг тийм хайнга байх ч гэж дээ. Дашрамд өгүүлэхэд монголчууд бидний бүтээлийг хүмүүс ингэж үнэлж байхад “HD Монгол” телевизийн “Авьяаслаг Монголчуд” нэвтрүүлэг уртын сайхан дуучныг “хөгшин” хэмээн хасч нийгмийн шүүмжлэлд өртөж байна.

МУИС-ийн сэтгүүл зүйн эрдэм шинжилгээний бичигт Радиогийн ахмад сэтгүүлч, СГЗ Л.Гүнсэн “Жараад оныг

радио найруулал хөл дээрээ боссон, ер нь цэцэглэж эхэлсэн үе гэж хэлж болно. Нэвтрүүлгийн шинэ содон санаа хэлэхдээ авхаалжтай, одоо бодоход тэр үдээ сэтгүүл зүйн “генератор” болж байсан Жамбалын Зундуй” гэдэг хүн Мэдээлэл, радиогийн улсын хороог толгойлж байхад 1961 онд тэр хүний санаачилгаар Зөвлөлтийн радиогоос туршлагатай найруулагч, сэтгүүлч хоёрыг соёлын төлөвлөгөөгөөр урьж ирүүлэн, нийт уран бүтээлчдэд радио сурвалжлага, радио найрууллын талаар хоёр хоногийн хичээл семинар явуулж, юу сурсан мэдсэнээ амьдралд хэрэгжүүлэхээр манай уран бүтээлчдээс тэдэнтэй хамт томилолтоор хөдөө хүртэл явж байсан. Сэтгүүлч Л. Шаравжамцын “Сайн сайхан бүхнийг ийм хүмүүс авчирна”, Г. Гомбын “Тугийн цоморлиг” зурагласан радио найрууллууд ингэж бүтсэн түүхтэй. Нэгийг нь нийслэлийн 6 дугаар сургуулийн хөдөлмөр зуслан, нөгөө нь Сөгнөгөрийн пионерийн зусланд очиж хийсэн эдгээр шинэ нэвтрүүлгийг нийт уран бүтээлч ажилтнууд асар их сонирхож, анхаарал тавин сонсож ярилцаж, их зүйл шинээр мэдэж авч байсан билээ”¹ гэж бичжээ. Сайн нэвтрүүлгийн төлөө сургалт, дадлага, гүйцэтгэх үйлийг нэг дор явуулж үр дүн гарч байжээ. Радиогийн нэг нэвтрүүлгийн төлөө энэ мэт ажил болдог туршлага өмнө ч байсан. Түүхээс үзэхэд, Улсын радио хорооны дарга байсан Л Пүрэвийн дурсамж ярианд “...Ч. Лодойдамба, инженер Ц.Мятав, техникч Д. Пүрэв бид Төв аймгийн Баянцагаан суманд очсон юм. Тэгэхэд хөдөө цахилгаан байхгүй болохоор цэргийн яамнаас Л-3 дизель

моторыг нь гуйж аваад айлдаа очоод тэргүүний малчдыг яриулсан. Гэтэл пад пад хийсэн моторын дуу орчихоод болдоггүй. Арга буюу мотороо холдуулж дээр нь нэг муу хар гэр бариулж, хаалга тооныг нь битүүлээд мотороо эсгийгээр бүтээсэн. Бас болдоггүй ээ, утас нь хүрдэггүй. Арай ядан утсаа хүргэж шөнөжингөө юм болсоор анхны радио сурвалжлага хийсэн дээ. Хонь майлж, үхэр мөөрөхийг хүртэл цөмийг нь бичсэн. Радиодаа эргэж ирээд “ийм тэргүүний малчных одоо ингэж ярина” гээд нөгөө сурвалжлагаа нэвтрүүлсэн. Тэгсэн чинь улсууд их гайхаж “Үгүй ээ, энэ чинь юу болж байна вэ? Радиод чинь бүр хонь ямаа аваачаад майлуулж байгаа юм биш биз дээ” гэхэд зарим нь, өнөө студи нь муу болохоор гадуур явсан малын чимээ гарсан байлгүй дээ” гэлцэж байсан² гэжээ.

Хэдийчинээ сэтгэл, зүтгэл гаргана, хүмүүсийн сэтгэлд төдийчинээ хүрдэг байна. Мэдээллийн цахим хуудаснаас “халбагадах”, эсвэл хүмүүсийн яриаг хэд таслан, хөгжим, аялгуугаар хагас хугас чимэглэн оруулах нь хайш яйш сэтгэлээс хол хөндий болно. Техник технологийн хөгжил ахих тусам радио нэвтрүүлгийн чанар дордох бус сайжрах учиртай. Хорь, гуч, дөч, тавин жилийн өмнөх нэвтрүүлгийн чанарт

хүрэхгүй байгааг сонсогч түмэн шүүмжилж байна.

Ишлэл

¹ МУИС-ийн НУФ-ын эрдэм шинжилгээний бичиг. 2003 , № 206 /18/. х. 60-61.

² *Батжаргал Д., Мэндхүү Г.* 2015. Радиогийн тухай: А-Я хүртэл. УБ., х. 14-15.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. “Лоолой... лоолой” нийслэлийн “Амьдрах ухаан” нэвтрүүлгийн бичвэр. 1992.

2. МУИС-ийн НУФ-ын эрдэм шинжилгээний бичиг. 2003 , № 206 /18/.

3. *Батжаргал Д., Мэндхүү Г.* 2015. Радиогийн тухай: А-Я хүртэл. УБ.

Резюме

В настоящей статье автор затрагивает проблемы развития жанров радиовещания Монголии. С середины 60-х годов XX века на монгольском радио ужесточили требование к качеству программ и передач, в том числе жанрам. В то время радиожурналисты нашей страны освоили новые для них жанры и появилось множество передач разных жанров, такие как репортаж, радиоочерк и программы художественно-публицистического рода. Автором отмечается недостатки профессионального мастерства современных радиожурналистов.